



ХАСБАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ЗАРЛАЛ

Компанийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1 дэх хэсгийг үндэслэн ХасБанк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн R-2025-28 дугаар тогтоолын дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (“ХЭЭБХ”)-ыг эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар зохион байгуулж буйг үүгээр зарлаж байна.

Компанийн нэр, байршил: ХасБанк ХК, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Ерөнхий Сайд Амарын гудамж, ХасБанкны Төв Байр, ШХ 20А, 72.

Хувьцаа эзэмшигчдэд саналын хуудас хүргүүлэх өдөр: 2025 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Брокер, дилерийн компаниудад хүргүүлж, ХасБанкны вебсайт, ХасМийтинг (ХасMeeting) аппликейшнд байрлуулна.

Эчнээ санал цахимаар хүлээн авах хугацаа: 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрөөс 2025 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн хооронд хүлээн авна.

Бүртгэлийн өдөр: ХЭЭБХ-д оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр нь 2025 оны 07 дугаар сарын 21-ний өдөр байна.

ХЭЭБХ-аар шийдвэрлэх асуудал:

- ХасБанк ХК-ийн Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай: Монгол хэл дээрх эхийг англи хэл дээрх эхэд нийцүүлэх.
- ХасБанк ХК-ийн Дүрэмд өөрчлөлт оруулах тухай: Зөрүүтэй байдал үүссэн тохиолдолд монгол хэл дээрх эхийг баримтлахаар тогтоох.

Хувьцаа эзэмшигч та хурлын материалтай танилцах бол 2025 оны 07 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн банкны цахим хуудсанд (www.xacbank.mn) эсвэл хувьцаа эзэмшигчдийн хуралд зориулагдсан ХасМийтинг аппликейшн-д хандах боломжтой. Та эчнээ саналаа заасан хугацаанд ХасМийтинг аппликейшнээр дамжуулан цахим хэлбэрээр өгнө үү.

Холбоо барих: ☎ +(976)-8508-1888 ✉ investor-relations@xacbank.mn

🕒 Ажиллах цагийн хуваарь: ажлын өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд.

2025 оны 07 дугаар сарын 02-ны өдөр
ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

